



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/406

Есөнбулаг

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.1.21 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалт Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Биеийн тамир спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалт, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2024 оны 18 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.4.2, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.2 дахь хэсгийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор ерөнхий боловсролын сургуулиудын дунд зохион байгуулагдаж байгаа "Мөрөөдлийн гоол 2023-2024" улсын аварга шалгаруулах шигшээ тэмцээнд оролцох тамирчдын замын, зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

2.Шаардагдах 4,000,000 (дөрвөн сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг) Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

